


ЭРХЭМ ХАРИЛЦАГЧ ТАНАА

Танд энэ өдрийн мэнд хүргэе. Юуны өмнө манай “Булл Капитал ББСБ” ХХК-д Итгэл хүлээлгэн хамтран ажиллаж буй танд талархаж буйгаа илэрхийлье. Бид эрсдэл тооцсон, мэргэжлийн үйл ажиллагааг чухалчлан ажиллаж байгаа ба Компанийн 2023 оны II улирлын үйл ажиллагааны товч тайланг үүгээр хүргэж байна.

Манай компанийн хувьд 2023 оны II улиралд бизнес төлөвлөгөөний дагуу тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн ханган ажиллалаа. Үүнд:

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	2023 оны II улиралд дүрмийн санг 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 8.7 тэрбум төгрөгт, өөрийн хөрөнгө 11.2 тэрбум төгрөгт тус тус хүрсэн.
2	Санхүүгийн байгууллагууд болон Булл бонд-1, Булл бонд-2-ын хөрөнгө оруулагчид мөн Итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлэн ажиллалаа.
3	Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд 3 ажилтан шинээр нэмж, нийт үндсэн ажилтны тоо 22 болсон.
4	Ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор компанийн дотоод сургалтыг 6 удаа, гадаад сургалт, хэлэлцүүлгүүдэд (Монгол банк болон СЗХорооноос зохион байгуулсан “Комплайнс удирдах хэлэлцүүлэг”-г, СЗХорооноос зохион байгуулсан “Итгэлцэлийн үйл ажиллагааны журам” хэлэлцүүлэгт, “Комплайнс-Удирдах ажилтны манлайлал” сургалт, “ББСБ-ын нягтлангуудын сургалт”) тус тус хамруулсан байна.
5	Импортын автомашин худалдааны тэргүүлэгчдийн нэг “Автомарт” худалдааны төвийг түшиглэсэн салбар байгуулах ажлыг эхлүүлсэн.
6	Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Санхүүгийн газраас мөнгөн урсгал төлөвлөлтийг долоо хоног бүр, Эрсдэл хариуцсан нэгжээс зээлийн эрсдэлийн хяналтыг өдөр бүр хийж байна.
	Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр:
7	ТоС холбооны гишүүн байгууллагын хувьд ТоС Холбооноос хэрэгжүүлсэн " <u>Эдийн Засгийн Ногоон Шилжилт / Switching On the Green Economy</u> " төслийн хүрээнд боловсруулагдаж буй " Эко тэмдэг, ногоон баталгаажуулалтын схем " ажлын хэлэлцүүлэгт оролцсон.
8	" Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023 (ТоС долоо хоног) " олон улсын манлайлын хөтөлбөр, өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг бүхий форум арга хэмжээнд оролцсон.
9	ТоС Холбооны Евролын холбооны СВИЧ- Эйшиа хөтөлбөрийн хүрээнд " <u>Эдийн Засгийн Ногоон Шилжилт / Switching On the Green Economy</u> " төслийг Пипл Ин Нийд ОУТББ, Хөгжлийн Шийдэл ТББ болон Каритас Чех Репаблик ОУТББ-тай хамтран хэрэгжүүлж байгаа " Эко тэмдэг, ногоон баталгаажуулалтын схем " анхан шатанд боловсруулагдан баримт бичгийн цахим хэлэлцүүлэгт оролцсон.
10	Тэргүүлэгч арилжааны банк, санхүүгийн байгууллагууд, дотоодын зах зээлд тэргүүлэгч даатгалын компаниуд, мөн Англи улсад үйл ажиллагаа явуулдаг давхар даатгалын ION insurance компаниудтай хамтын ажиллагаа улам өргөжин тэлсэн.
	Нийгмийн хариуцлагын хүрээнд:
11	Эх үрсийн баярыг угтан нийт ажилтнуудынхаа хүүхдүүдийн дунд уралдаан зарлаж, хүлээн

	авалт хийсэн ба аав, ээжийнх нь ажлын байртай танилцуулж, компанийн зүгээс хүүхдийн баярын бэлэг гардуулсан.	
12		Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр зохион байгуулагддаг байгаль орчинд ээлтэй ажлын хүрээнд хамт олноороо 2023 оны 6-р сарын 18-ны өдөр Сонгинохайрхан уулын ойр орчмын хогийг цэвэрлэсэн.

Эрсдэлийн бодлого:

Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, төрийн зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэрийг анхааралтай ажиглаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч ажиллаж байна. Энэ хүрээнд өмнөх оноос хэрэгжүүлж эхэлсэн дараах шийдвэрүүдийг мөрдсөөр байна.

1. Төвлөрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэг харилцагчид 100.0 сая төгрөгөөс дээш хэмжээний зээл олгохгүй байх,
2. Эдийн засгийн сектороор хязгаарласан зээлийн багцын хязгаарууд болон барьцаа хөрөнгийн үнэлгээний бодлогыг чангаруулах,
3. Уул уурхай, барилгын салбар болон эдгээр салбаруудтай хамаарал бүхий орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээл олгохгүй,
4. Өр орлогын харьцааны шаардлагыг чангаруулах.

Санхүүгийн үзүүлэлт:

Бид Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллаж байгаа ба 2021, 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны II улирлын санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлтүүд /сая.төг/	2021	2022	2023 II	Өөрчлөлт
	Аудитлагдсан	Аудитлагдсан	СЗХ-нд илгээсэн	2023 II/2022
Санхүү байдлын тайлан				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12.56	2,209.36	2,070.88	-6%
Нийт зээл	1,931.89	22,223.77	34,683.41	56%
Зээлийн эрсдэлийн сан		-124.27	-165.16	33%
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	39.84	626.34	801.59	28%
Бусад авлага	5.64	217.12	138.58	-36%
Бусад хөрөнгө	16.82	40.65	43.39	7%
Үндсэн хөрөнгө	20.85	173.63	164.25	-5%
Нийт хөрөнгийн дүн	<u>2,027.61</u>	<u>25,366.60</u>	<u>37,736.95</u>	49%
Итгэлцэл, бусад өр төлбөр	604.80	16,314.42	26,462.39	62%
Дүрмийн сан	1,400.00	7,400.00	8,699.83	18%
Хуримтлагдсан ашиг	22.81	1,652.17	2,574.73	56%
Нийт өр төлбөр, эзний өмчийн дүн	<u>2,027.61</u>	<u>25,366.60</u>	<u>37,736.95</u>	49%

Орлого үр дүнгийн тайлан				
Хүүгийн орлого	69.97	4,109.23	5,250.58	28%
Хүүгийн зардал	8.56	963.16	1,136.99	18%
Цэвэр хүүгийн орлого	61.41	3,146.07	4,113.59	31%
Хүүгийн бус орлого	9.71	229.49	393.38	71%
Хүүгийн бус зардал	44.54	1,390.35	1,587.01	14%
Эрсдэлийн сангийн зардал	0.00	124.27	40.89	-67%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	26.57	1,860.94	2,879.07	55%
Ү/А-ны бус орлого				
Ү/А-ны бус зардал	3.50	47.49	18.06	-62%
Татвар төлөхийн өмнөх ашиг	23.08	1,813.46	2,861.01	58%
Орлогын татварын зардал	0.27	184.09	286.46	56%
Цэвэр ашиг	22.81	1,629.37	2,574.55	58%

2023 оны II улирал болон 2022 оны жилийн эцсийн Санхүүгийн гол үзүүлэлтүүдийг харьцуулахад Нийт хөрөнгө 12.3 тэрбум төгрөг буюу 49%-иар, Зээлийн багц 12.5 тэрбум төгрөг буюу 56%-иар тус тус өссөн. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 1.36% байгаа ба системийн дундажаас 5.8 дахин бага, чанартай үзүүлэлт байна.

Банк, санхүүгийн байгууллага болон Итгэл хүлээлгэгч, Хөрөнгө оруулагч нараас эх үүсвэр нэмж татсанаар бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн 26.5 тэрбум төгрөгт хүрч, 2022 оны жилийн эцэстэй харьцуулахад 62%-иар өссөн байна.

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнд 2023 оны II улирлын байдлаар татварын дараах цэвэр ашиг 2.57 тэрбум төгрөгт хүрч, Санхүүгийн зохицуулах хорооноос тавьдаг зохистой харьцааны бүх шалгууруудыг ханган ажиллалаа.

“БУЛЛ КАПИТАЛ ББСБ”ХХК

2023.07.18